

ОНГОН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
05 ДУГААР САРЫН МЭДЭЭ

2023.05.29

Хавирга

Нэг. Удирдлага зохион байгуулалтын чиглэлээр:

Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Тамгын газар, төрийн удирдлагын ажлын чиглэлээр

Засаг даргын зөвлөлийн хурлыг 1 удаа зохион байгуулж цаг үеийн ажлуудын гүйцэтгэл, шийдвэрлэх ажлуудыг хэлэлцэж шийдвэрлэсэн.

Багуудын иргэдийн нийтийн хурлыг зохион байгуулж, төрийн ажлын мэдээллийг хүргэн, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэх ажлын санал авах ажлыг зохион байгуулсан.

“Сүхбаатар аймаг-Хөгжилд хамтдаа” хөрөнгө оруулалт, хөгжлийн чуулганд шаардлагатай материалыг бэлдэж оролцсон.

Хоёр. Эдийн засаг төсөв санхүүгийн бодлогын хүрээнд:

Монгол улсын Засгийн удирдлага мэдээллийн цахим сүлжээг ашиглан төсвийн байгууллагуудын төлбөр тооцоог өдөр тутам хийж гүйцэтгэн холбогдох тайлан мэдээнүүдийг тогтмол гарган өгч байна.

2023 оны эхний хагас жилийн мал тооллогын ажлын хэсгийг сумын засаг даргын захирамжаар баталж, гишүүдийг сургалтанд хамруулсан.

Нийгмийн даатгалын байцаагчтай тухай бүр тооцоо нийлж, өр авлагагүй ажилласан.

Сар бүрийн төсвийн орлого, зарлагын гүйцэтгэлийн мэдээ, төрийн сангийн мэдээ, өглөг авлагын мэдээг хугацаанд нь үнэн зөв гаргаж цахим сүлжээгээр дамжуулан төрийн сангийн хэлтэст өгсөн.

Гурав. Хууль эрх зүйн бодлогын хүрээнд:

Эрх зүйн хөтөч 4 албан хаагчийг Эрх зүйн хөтөчийг чадавхжуулах сургалтанд хамруулсан.

Газрын харилцаа, газартай холбоотой хууль эрх зүйн мэдээлэл өгөх, иргэдийн хүсэлтийг шийдвэрлэх “Нээлттэй хаалганы өдөр”-ийг зохион байгуулсан.

Засаг даргын тамгын газрын пейж хуудсаар иргэдэд хууль, эрх зүйн мэдээлэл хүргэх сурталчилгааг 3 удаа байрлуулсан.

Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн 04 дүгээр сарын хэрэгжилтийг цахим системд байршуулсан.

Дөрөв. Боловсрол, соёл, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын бодлогын хүрээнд:

Үндэсний бичиг соёлын өдрөөр төрийн албан хаагчдын дунд “Монгол бичиг мину” уралдааныг зохион байгуулж, 5 байгууллагын 25 албан хаагч 5 төрлөөр Үндэсний бичгийн мэдлэг, чадвараараа өрсөлдсөн.

Сумын эрүүл мэндийн төвд улсын төсвөөр Приус-30 суудлын автомашин олгогдож, парк шинэчлэл хийгдсэн.

Аймгийн нэгдсэн эмнэлгийн нарийн мэргэжлийн эмч нарын “Явуулын амбулатори”-ийн баг 5 сарын 12-15-ны өдрүүдэд ажиллаж иргэдэд эрт илрүүлэгийн үзлэг болон урьдчилан сэргийлэх үзлэгийг зохион байгуулсан.

“Хүүхдийн хөгжил хамгаалалыг дэмжих жил”-ийн ажлын хүрээнд сумын Хүүхдийн чуулганыг зохион байгуулсан.

Соёлын төвийн бүжгийн багш О.Батзаяа МУТТА Б.Мөнхтулга нарын “Жаргаж дуулья” тоглолт 30 хүүхэд, 281 том хүн үзсэн.

Соёлын төв “Хүүхдийг дэмжих жил”-ийн хүрээнд байгууллагатаа албан хаагчдын хүүхдүүдэд зориулж “Хүүхдийн өрөө” шинээр тохижуулсан.

Үндэсний бичиг үсэг – Номын баярт зориулан “Нутгийн зохиолчдын” номын үзэсгэлэнг 7 хоногийн хугацаатайгаар зохион байгуулсан.

Зорилтот бүлгийн иргэдийг нутгийн түүх соёлын дурсгалт газартай танилцуулах, зорилгоор нэг өдрийн аялал зохион байгуулж аяллын хүрээнд Шартадын хаданд ургадаг эмийн ургамал, ан амьтан , байгалийн өвөрмөц тогтоц , зан заншлын талаар мэдээлэл өгсөн.

Сургуулийн өмнөх боловсролын хувилбарт сургалтын чанарыг сайжруулах зорилгоор шинэ залуу багшийг 6 сар дадлагажуулан зайны багштай бэлтгэж, танхимаар хамрагдаж чадахгүй байгаа оторын өрхийн хүүхдүүдтэй гэрээр болон зайнаас ажиллаж байна. Өнөөдрийн байдлаар оторт явсан 12 өрхийн хүүхдэд үнэлгээ хийж зохих түвшиний даалгавар багцыг өгч эргэх холбоотой ажиллаж байна.

“Шувуухай 2023” хүүхдийн урлагын наадамд хүүхдүүддээ бүжгийн хамтлаг 2 дугаар байр “Мөнгөн” медаль хүртсэн.

Мөн цэцэрлэгийн багш, ажилчид өөрсдийн нөөц бололцоогоор 12 хүний урлагийн үндэсний хувцас болон чөлөөт хувцасыг өөрсдөө урлан бүтээж иж бүрэн 12 хүний бүжгийн хувцсыг 922.000 төгрөг зарцуулсан.

Тав: Хөдөө аж ахуй, байгаль орчны бодлогын хүрээнд:

Монгол улсын Ерөнхийлөгчийн 2021 оны 58 тоот зарлиг, Засгийн газрын 2021 оны 350 тоот тогтоолын дагуу “Тэрбум мод үндэсний хөдөлгөөн”-ий хүрээнд нийтийн эзэмшил газарт 650 мод тарьж, модны усалгаа, арчилгаа орчныг цэвэрлэх ажлыг зорилтот бүлгийн иргэдээр хийлгэж байна.

Бүх нийтийн их цэвэрлэгээг зохион байгуулж, нийтийн эзэмшил газар, сумаас гадагш 2 км газарт төрийн албан хаагчид цэвэрлэгээ хийж, хогийн цэгийн хашааг засварласан.

Сумын төвийн хогийн нэгдсэн цэгийг цэгцлэх ажлыг зохион байгуулсан.

Сумын 1, 3 дугаар багийн нутагт орших “Сүүж” нуурын усны ундаргыг сэргээх , хамгаалах, нөхөн сэргээх техникийн шийдлийг боловсруулах гидерогеологийн судалгааны ажлыг гэрээгээр хийлгэх ажлыг эхлүүлсэн.

МЭДЭЭ БОЛОВСРУУЛСАН:
ХЭЗ-Н МЭРГЭЖИЛТЭН

С.АЗБИЛЭГ